



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/29/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: С.Санчирмаа
	Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.05 № 16

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийтийн номын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийтийн номын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар ажилтны цалинг зөрүүтэй тогтоож ажилтанд цалин дутуу олгосон, бараа ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн, төсвөөс төлбөрийн актыг төлсөн, гэрээний заалт зөрчин ажил гүйцэтгээгүй байхад хөлсийг шилжүүлсэн, албан хаагчдад хоолны мөнгийг давхардуулан олгосон зэрэг 13,632.8 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.4, 16.5.5, 22.1, 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 заалттай тус тус нийцэхгүй, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 14,961.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 7 зорилт 28 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 23 арга хэмжээг бүрэн, 4 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээ 50.0 хувь буюу нийт дүнгээр 96.4 хувиар биелэлтийг хүргүүлсэн боловч ажлын дүгнээгүй байна.

07020926

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	55,354.4	58,003.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,485,880.2	1,458,460.1
	Нийт хөрөнгийн дүн	1,541,234.6	1,516,463.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	4,822.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,541,234.6	1,511,640.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,506,818.1	2,120,542.3
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,977,049.0	421,601.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	436,462.2	451,195.2
	Үйл ажиллагааны үр дүн	-	-
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,540,586.8	(29,594.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,526,888.3	1,541,234.6
	Тайлант оны үр дүн	14,346.2	(29,594.1)
	Эцсийн үлдэгдэл	1,541,234.6	1,511,640.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	450,808.4	420,401.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	396,773.4	427,415.5
	Үйл ажиллагааны ЦМГ	54,035.0	(7,014.3)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(29,011.6)	(9,579.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	25,023.4	(16,593.9)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,023.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,023.4	8,429.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	445,095.6	436,995.1
	Урсгал зардал	445,095.6	436,995.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	445,095.6	420,401.2
	Улсын төсвөөс санхүүжих	350,301.7	325,607.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	92,400.9	92,400.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,393.0	2,393.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,171.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Авлагыг 285.8 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд 885.5 мянган төгрөгөөр зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 13,632.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,632.8 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 12,511.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 3 албан шаардлага, 1,121.4 мянган төгрөгийн орон нутгийн орлого болгох болон ажилтанд буцаан олгох төлбөрийн актыг тогтоож хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актаас 60.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын дансанд төсвөөс төлсөн 60.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, биелэлтийг ирүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Албан хаагчийн цалинг зөрүүтэй тогтоож, 1,061.4 мянган төгрөгийн дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтанд дутуу олгосон 1,061.4 мянган төгрөгийн цалинг буцаан олгож, биелэлтийг ирүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 3,306.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтын "бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянана." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

3. Манлай Алтай ХХК-тай байгуулсан гэрээний заалтыг зөрчин ажил хийгээгүй байхад 3,400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ажил гүйцэтгэх гэрээний 3 дугаар зүйлийн 3.2-т "ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг хүлээлгэн өгсөн үед ажлын хөлсийг төлнө" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дагуу ажлыг хийж гүйцэтгэж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

4. Албан хаагчдад хоолны мөнгийг давхардуулан 5,805.0 мянган төгрөгийн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийтийн номын сан	2	1.2	2	1.2			2	1.2				
Дүн	2	1.2	2	1.2			2	1.2				

/сая төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Нийтийн номын сан	5	13.6	2	1.1	3	12.5	-	-	-	-	-	-
Дүн	5	13.6	2	1.1	3	12.5	-	-	-	-	-	-

/сая төгрөгөөр/

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		